



Published in the Russian Federation
 Oriental Studies (Previous Name: Bulletin of the Kalmyk Institute for
 Humanities of the Russian Academy of Sciences)
 Has been issued as a journal since 2008
 ISSN: 2619-0990; E-ISSN: 2619-1008
 Vol. 41, Is. 1, pp. 78–86, 2019
 DOI 10.22162/2619-0990-2019-41-1-78-86
 Journal homepage: <https://kigiran.elpub.ru>

УДК 811.512.37

О происхождении некоторых топонимов в эпосе «Джангар»*

Буудангийн Менгкай¹

¹ Институт монгольской филологии и культуры, Северо-Западный университет национальностей
 (д. 1, Северо-Западная Нью Виллидж, г. Ланьчжоу 730030, Ганьсу, КНР)
 доктор филологических наук (Ph.D.), профессор
 ORCID: 00000000. E-mail: mengke64@163.com

Аннотация. В статье поднимаются актуальные вопросы, касающиеся проблемы эпической топонимики в калмыцком героическом эпосе «Джангар». Рассматриваемые аспекты проблемы представляют особый интерес для выявления исторического содержания эпического текста. В эпических песнях «Джангара» многие названия природных объектов связаны с исторической средой обитания ойратов (калмыков) — Алтаем. Алтайская топонимика является универсальной особенностью для всех эпических сказаний монгольских народов. Вместе с тем в песнях «Джангара» также обнаруживается топонимическая лексика, которая могла войти в текст эпического сказания калмыков после их переселения на Волгу в начале XVII в. По мнению некоторых эпосоведов, именно в эпической традиции калмыков произошла циклизация песен «Джангара». Автор статьи рассматривает в «географии» калмыцкого эпоса возможные восточноевропейские и среднеазиатские элементы топонимики.

Ключевые слова: «Джангар», Бумба, оронимы, гидронимы, топонимы, потамонимы, этнонимы

Для цитирования: Б. Менгкай. О происхождении некоторых топонимов в эпосе «Джангар». Oriental Studies. 2019;(1):78-86. DOI: 10.22162/2619-0990-2019-41-1-78-86

UDC 811.512.37

The *Jangar* Epic: Origins of Some Toponyms Revisited

B. Mengkai¹

¹ Institute of Mongolian Philology and Culture, Northwest University for Nationalities (1, Northwest New Village, Minyin Rd, Chengguan, Lanzhou 730030, Gansu, People's Republic of China)
 Ph.D. in Philology, Professor
 ORCID: 00000000. E-mail: mengke64@163.com

Abstract. The article deals with epic toponymy which is of particular interest to clarify the history of the Kalmyk heroic epic *Jangar*. Names of natural objects remain preserved for thousands of years, so they are of high historical value. The analysis of epic place names makes it possible to trace the ethnic and migration processes in a certain area, to identify cultural contacts between different ethnic groups

* Данная работа публикуется в целях дискуссии на обозначенную тему. Редакционная коллегия не разделяет мнение автора. — *Прим. ред.* [The work is published to facilitate to further research discussions on the topic mentioned. The Editorial Board does not share the author's view.]

and to recreate the ethno-cultural background. In *Jangar* epic songs, some names of natural objects are associated with the Altai which is a characteristic feature of the entire epic of Mongolic peoples. Those also contain toponymic vocabulary that could have been included into the text of the epic tale of the Kalmyks in the Volga Region already where, according to the assumption of authoritative experts in epic studies, the cyclization of *Jangar* songs could have taken place. The paper attempts to substantiate into the 'geography' of the Kalmyk epic using the Eastern European and Central Asian toponymic elements.

Keywords: *Jangar*, Bumba, oronyms, hydronyms, toponyms, potamonyms, ethnonyms

For citation: Mengkai B. The *Jangar* Epic: Origins of Some Toponyms Revisited. *Oriental Studies*. 2019;(1):78-86. DOI: 10.22162/2619-0990-2019-41-1-78-86



«Жангар» туулийн олонх бүлгүүдэд 'Ар Бумбын орон'-ы хил хязгаар, дүрс байдал, орчин тойрны тухай маш нарийн дүрслэн танилцуулахаас алдар ноён Жангарын хаан ордны бэлгэдэл болсон 'Арван давхар, есөн өнгийн алтан торлог байшин'-гийн орчин тойрон дахь уул ус, гол мөрөн, нуур тэнгисийн тухай дэлгэрэнгүй танилцуулдаг. Ер нь, зүг чиглэлийн нарийн тодорхой заалттай, нутаг усны үнэн бодитой нэрлэлттэй байдаг нь «Жангар»-ын бусад туульсаас ялгагдах чухал нэг онцлог мөн.

Жишээлбэл: *Өлө Маңхын Цаһан уулни / Газыр, тэңгер хойрин киисен болад, / Өрүн хархь нарни көл дорь / Маңхаһад бээдег гинэ. / Өргөн Шартыг гидег далани / Өрү, сөрү хойр урьсхьлта, / өнгөтэ бадмиин гэрел һарад бээдег гинэ. / Эзен Жаңһыр эврэн бийни уудыг / Киитн харь Домбь һолни / Өвөл зуун уга урьсхьлта, / Үргелжэи гадьр эрген балвълън / Бульгълън бээдег. / Эркен Бумбан Цаһан өргэ дотран / Шаран зурһан миңһен / Арвэн хойр баатърни / Сууһад күүндегсен үгени эне: / — Эзен нойһн Жаңһыртан/ Энэ нарһн дорьуга / Бээшөң бэрүлейе! — гисен суудыг. / Дөрвөн төвиини / Дөчин хойр хаһан цуглулжэи ирэд, / — Йамьр дүңгәһазьртэ бэрейе? — гижэи / Зөвчилжэи күүндегсен. / — Нарһн һархиин арь бийе талъ, / Артэ арвэн хойр далан цутхълъндэ, / Бумбь дала гидег далан көвөдэ, / Өлө Маңхын Цаһан уулын / Барун өргөн дорь, / Тальвинцаһан ташудь, / Тавьнзуун һалвэр зандьн уласни сүүдрииге / Дахулъй, — гижэи күүндегсен болна [Жаңһыр 1978: 369–370] — хэмээн нэлээд олон бүлгийн эхэнд бараг адил зарчмаар хэлэгддэг. Үүнээс гадна бас догшин Хар тэнгис, Цагаан тэнгис, Хойт мөсөн далай, Авхай балгад далай, Эрчис Бумба буюу*

Эрчис гол, Шихэрлуу, Мин уул зэрэг олон арван нуур далай, гол мөрөн, уул усны тухай дахин дурдагдана.

Халимагийн алдарт эрдэмтэн А. Ш. Кичиков «Жангар» дуулврин харлһин тухай зохиолдоо: «Жаңһрахн уулта, модта, усн далата һазрт, эргн ик мөрн һолта орнд бүүрлсэр үзүлгднэ. Нег миңһн тавн зун жилин хооран хальмг улсин хол урдкэ сәнби татаби, шивей, татар гих нертэ, монһл келтэ нутгуд ик хол дорд үзгт, Амур һолас өмөрөн, ода цагин Корей орна ар захар йовцхасн бээж. Ода карт аһад хөлөхлө, тедн Хинган гидг уулын нуру дор, Дала-нуур гилг уста, оһн һолта һазр алднд бүүрлэд йовдг чигн бээсн бээдлтэ» [Кичгэ 1974: 6] гэж тэмдэглэсэн байна.

Эдгээр уул ус газар орны бодитой байршлын тухай цөөн хэдийг нь тодруулж эс чадавч олонхийг нь бүр нэг нэгээр тодорхойлж болох юм.

1. Өргөн Шарт далай

«Жангар»-т 'Өргөн Шартыг гидег далани' [Жаңһыр 1978], 'Өргөн Шарт гэдэг хоёр далай', 'Өргөн Шартаг далай', 'Өргөн Шарт гэдэг хоёр гол' [Жангар 1958; Жангар 1986] гэх мэтээр олон дахин тохиолдоно. Энэ нь нэрийн талаар ч гэсэн гол мөрний онцлогоороо ч гэсэн одоогийн Ижил мөрний дээд доорд хоёр урсгалын хэсгийг зааж байгаа гэдэг нь тов тодорхой байна. Нэрийнх нь талаар авч үзэхэд халимагууд одоогийн Ижил мөрнийг 'өргөн их Ижил мөрөн' гэж нэрлэдэг заншилтай байв. Үүнээс Ижилийн халимагууд ба Шинжааны ойрадуудын дотор одоо хүртэл уламжлагдан дуулагдаж байгаа 'өргөн их Ижил мөрөн' гэж нэрлэдэг заншилтай байв. Үүнээс Ижилийн халимагууд ба Шинжааны ойрадуудын дотор одоо хүртэл уламжлагдан

дуулагдаж байгаа «*Өргөн их Ижил Зай*» гэдэг ардын дуугаас тодорхой мэдэж болно. Ижил мөрөн үнэхээр өргөн уужим далай мэт томгол болохыг үзсэн бүхэн гэрчилнэ. Зай мөрөн (өдгөө Урал мөрөн) 2428 км урсхлта. Зай хэмээн тюрк хэлни *jayik* 'өргөн, уужим' гисэн үг.

Тэгвэл «Жангар»-т энэхүү Ижил мөрнийг яагаад «*Өргөн Шарт гэдэг хоёр далай*» (зарим бүлэгт гол гэж хэлэгдэнэ) хэмээн салган хэлж байна вэ?

Үүнийг одоогийн газрын зураг дээрээс үзвэл тодорхой мэдэж болно. Даруй Ижил мөрний дундад урсгалын хэсэг нь одоогийн ОХУ-ын Саратов мужийн тал дундуур өнгөрөхдөө нэгэн нарийхан хоолой болон «*Өргөн Шарт хоёр далайг*» хэлхэж байдаг бөгөөд энэхүү нарийхан хоолойн хэсэгт нь зүүн хойт зүгээс нь Их Эрчис мөрөн цутгаж, баруун хойт зүгээс нь Ульяновск мужийн дунд хэсгээс эх аван урссан нэгэн гол ирж цутгадаг байна. Энэ орчимд өдгөө Саратовын усан цөөрөм (нарийхан хоолойн дээд хэсэгт буй) гэж байдаг ба 1590 онд байгуулагдсан энэхүү Саратов (халимагууд одоо ч Шарту балгасан гэдэг) хот нь оросын хилийн сэргийлэлтийн чухал боомтын орон байжээ.

Иймээс «Жангар»-т энэхүү нарийхан хоолойгоос дээших хэсгийг «*Шарт*» буюу «*Шартаг далай*» хэмээн нэрлэж, доорд хэсгийг нь Ижил мөрөн хэмээн нэрлэж байсныг «*Өргөн Шарт гэдэг хоёр далай*» гэдэг нэрийдлэгээр тодорхой илтгэсэн байна.

2. Ардай арван хоёр далайн цутгалан

«Жангар»-т: *Наран гарахын ар бие тал, / Гарбид их шилийн омруун тал, / Ардай арван хоёр далайн цутгалан, / Бумба далай гэдэг далайн хөвөөд, / Өл Манхан Цагаан уулын баруун эрүү доор, / Талбайн цагаан ташууд / / Өл манхан цагаан уулын өлгөнд, / ӨргөнШарт далайн цутгалан, / Алтанарлуудын аараг дунд, / Араат арван хоёр бүслүүртэй / Талибуу цагаан ташуугийн нүүрт* [Жангар 1958: 21] — гэх мэтээр Ардай арван хоёр далайн цутгалангийн тухай их нарийн танилцуулна.

Тодорхойлох нь, халимаг ойрадууд тэнгис далайгаас гадна бас өргөн том гол мөрнийг эртдээ «*далай*» хэмээн нэрлэдэг байсныг Эрдэмтэн А. Ш. Кичиков зохиолдоо: «Дала гисн хуучн цага келнд “океан” биш, урсхлта өргн хол (ик уста болснднь дала гиж келгднэ). Зүнһарин һазр

тиим өргн хол — Эрцс (Иртыш), Или, Хатн (Катунь) гиж бээнэ» [Кичгэ 1974: 62] гэж тэмдэглэсэн байна.

Ингэхлээр энэ «*далай*» гэдгийг гол мөрнөөр үзэх нь зүйтэй. Европ тивийн газрын зургийг үзэхэд алдарт Ижил мөрний доорд урсгалын цутгалангийн хэсэг нь үнэхээр арван хоёр салаа урсгал болж Каспийн тэнгист цутгадаг байна. Иймэрхүү өвөрмөц онцлогтой гол мөрний цутгаланг бид өөр газраас эрээд ер нь олохгүй. Энэ нь «Жангар» дахь «*Ар Бумбын орон*»-ы бодит байршлыг илэрхийлж болохуйц бас нэгэн сүвэгч юм. Үүнээс «Жангар» дахь «*ар Бумбын орон*»-ы уул усны нэрс бол хүслэнгийн буюу санаан дураараа зохиосон зүйлс бус гэдгийг улам нэг алхам бат итгэж болно.

3. Бумба далай

Дээр дурдсан Ардай арван хоёр далай нь «*Бумба далай*» гэдэг далайд цутгах тухай олон газарт адилхан өгүүлнэ. Ингэхлээр энэхүү «*Бумба далай*» гэдэг нь бараг Каспийн тэнгис мөн бололтой гэсэн бодол төрнө. «Жангар»-т энэ «*Бумба далай*»-н тухай:

Бумб дала гидг дала түшлһтә, / Бумб дала гидг дала / ... / Хойр эргән гүвдәд / Дольгалсн бәәдг; / Гүүнәннь кемжәнъ — / Бум нәәмн түмн берә гүн, / Өргәнәннь кемжәнъ — / Тунжур мөңгн толһата, / Улавр мөңгн өрвлһтә, / Эр барсин зүрктә, / Күүкн бүргд шүүрлһтә, / Туулжн шар цоохр итлгнь девхләрн, / Йирн берә һазр девдм, / Йир хурдн итлг, / Зууран күүкләж һатлм / Өргн Бумб дала. Хан нойн Жаңһрин дала гиж / Харин долан миңһн хаани зүүдн болв [Жаңһр 1990: 177] — гэж маш тодорхой дүрсэлсэн байдаг.

Үүнд хэдийгээр давуулсан зүйл илхэн мэдэгдэж байвч энэхүү маш өргөн их, гүн устай том далай гэдэг нь Каспийн тэнгисийн бодит байдалтай тохирч байна.

4. Эрчис ол

«Жангар»-т «*Эрчис бумба*», «*Эрчис далай*», «*Эрчис гол*» гэх мэт адил бус нэрээр олонтоо дурдагдана. Алдар Жангарын арван давхар есөн өнгийн алаг шар бамбалай нь энэхүү Эрчис голын баруун хөвөө, «*Өргөн Шарт далай*» болон «*Бумба далай*» гэдэг далайн эх хөвөөд байдаг тухай «Жангар»-ын адил бус бүлгүүдэд үргэлж дурдагддаг.

Энэхүү Эрчис голыг судлаачид бүр Алтай уулаас эх авч, Зайсан нуураар дамжин баруун хойш урсаж, Овь голтой нийлэн, Хойт мөсөн далайд цутгадаг Эрчис мөрөн,

бас Хар Эрчис, Хоо Эрчис, Хөх Эрчис гэж хэд хэдэн хэсэгт хуваадаг мөн хэмээн үзэж байлаа. Энэ нь Ази Еворопод ганцхан л Эрчис мөрөн байна хэмээн дөхөмхөн үзсэнээс болсон болов уу [Козин 1940; Борисенко 2004].

Үнэндээ дээр дурдсан Эрчис мөрнөөс гадна одоогийн Казакстаны Актюбинск мужийн хил дотор бас нэг Эрчис гол [Справочник 1994: 28] гэж байхаас гадна ОХУ-ын Саратов мужийн хил дотор Их Эрчис гэдэг бас нэг гол [Справочник 1994: 326] байдаг аж. Өмнөх нь Турхай голын баруун салаа урсгал байж, Их Эрчис гол нь Ижил мөрний зүүн салаа урсгал болно. Бидний үзэж байгаагаар, «Жангар» дахь 'Эрчис далай' буюу 'Эрчис бумба' гэдэг нь яг энэхүү Их Эрчис голыг зааж буй. Учир нь, энэхүү 'Эрчис бумба' нь яг 'Өргөн Шарт хоёр далай'-н дундах нарийхан хоолойд зүүн хойт зүгээс ирж нийлдэг нэлээд томоохон гол болно. Энэхүү гол нь зүг чиглэлийн талаар Жангарын алаг шар бамбалайн зүүн талд нь байх бодит байдалтай яг нийцэж байна.

5. Үйзэн

«Жангар»-т 'Үйзэн Алдар хааны хөвгүүн үеийн өнчин Жангар', 'Үйзэнгийн орон', 'Үйзэн нуур' зэрэг хэдэн янзаар хэлэгдэнэ. Эндээс: 'Үйзэн' гэдэг нь хүний нэр цол юм уу? Эсвэл газар усны нэр юм уу? — гэдэг асуудал гарч ирнэ. Үүнийг тодлохын тул холбогдол бүхий бичиг материалыг нарийвчлан үзсэнд 'Үйзэн' гэдэг нь газар орны нэр болохыг илэрхийлсэн гурван зүйлийн чухал баримт олдлоо.

Нэгдэх нь, төв Ази хийгээд зүүн Европын газрын зураг болно. Энэхүү зураг дээрээс үзвэл одоогийн ОХУ-ын европын хэсгийн зүүн өмнөд талд байх Их Үйзэн гол болон Бага Үйзэн гол гэдэг зэрэгцэн урссан хоёр гол байдаг байна. Энэ хоёр гол Оросын Саратов мужийн зүүн хэсгээс эх авч Казакстаны или Хасагстаны Уралск мужийн баруун өмнө хэсэг дэх Камыш-Самарские нуурууд цутгадаг байна. Уртынх нь хэмжээ бараг 650 км орчим [Справочник 1994: 95] болно.

Хоёр дахь материал бол «Торгуудын уг язгуур сүлжил» гэдэг түүхэн сурвалж бичиг болно. Тус сурвалж бичигт: «... түүнд ноёны уг дөрвөний цагт суугаад, ноён тавдагч Хээ вангийн цагт сайн хүн болон Туихай ахтай зургаан хүнд ,... чи нүүгүүд ойрадын орны Үзэнд одоод газар

хийгээд ноён тэргүүтэнд харж ирэгтүн» гээд илгээсэн» [Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ 1992: 328] хэмээн тэмдэглэж буй. Энд хоёр чухал сураг зангийг илтгэж буй.

Нэгд, цагийн талаар 'дөрвөний цагт' гэдэг нь Торгуудын хаант улс байгуулагдсан анхны цаг үеийг зааж буй. Учир нь «Торгуудын уг язгуур сүлжил» гэдэг сурвалжид: «Хо Өрлөгийн хөвгүүн Шүхэр Дайчин, Шүхэр Дайчны хөвгүүн Дөрвөн...» [Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ 1992: 330] хэмээн тов тодорхой тэмдэглэж буй. Олны мэдэгчээр Торгууд хаант улсын уг суурийг тавьсан хоёр гавъяатан бол Хо Өрлөг болон Шүхэр Дайчин эцэг хөвгүүн хоёр болно. Ингэхлээр энэхүү 'Дөрвөний цагт' гэдэг нь бараг XVII зууны тавиад оны орчмын цаг үеийг зааж байх нь мэдэгдэж буй.

Хоёрт, газар орны тухай чухал мэдээ болно. Тухайлбал: «...чи нүүгүүд ойрадын орны Үйзэнд одоод газар хийгээд ноён тэргүүтэнд харж ирэгтүн» гэдэг нь бас л Ижилийн Торгууд хаант улсын нутаг дэвсгэрийг зааж буй. Учир нь, энэ тэмдэглэлээс үзвэл 'Үзэн' гэдэг нь 'Ойрадын орон'-ы доторх нэг газар нутаг аж. Олны мэдэгчээр XVII зууны хориод оны орчмоор «Ойрадын чуулган»-ы зөвшөөрлөөр Ижил зүг нүүсэн торгууд, хошуудууд, ер нь өөрсдийгөө уг нутаг «Ойрадын нутаг»-аасаа салгаж үзээгүй байсныг эрдэмтэд олон талаас нотолсон байлаа [Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ 1992: 68]. Тэгж хэлэхэд «Дөрвөний цагт ... ойрадын орны Үйзэнд одоод» гэдэг тэмдэглэлийг хооронд нь холбон үзвэл Торгууд хаант улсын цаг үе хийгээд тэдний нутаг дэвсгэрийг зааж байгаа нь тов тодорхой байна.

Гурав дахь чухал материал бол Энх-Амгалангийн тавин нэгдүгээр он (1712 он)-ы зуны дунд сард бичсэн «Чин улсын Энх-Амгалан хаанаас Торгуудын Аюук хаанд өгсөн бичиг» болно. Тус бичигт: «...Эдүгээ мөрт их хэрэгч элч илгээх учир, Вэ зан дор тэнгэр хүнийг удирдагч» [Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ 1992: 455] гэдэг сонирхолтой тэмдэглэл буй. Олны мэдэгчээр 1712 онд 32 хүнээр бүрэлдсэн Чин улсын элчийн бүлгэм нь Энх-Амгалан хааны зарлигаар алс холын Ижилийн Торгууд хаант улсад элч илгээсэн билээ. Дундад улсын түүхэнд хамгийн анх удаа европын улсад элч илгээсэн энэхүү элчийн бүлгэм нь Хаант Оросын харшлалаас болж хоёр жил гаруй хугацаа зарцуулаад 1714 оны 7 сарын 12-ны өдөр Ману тохойд

байсан торгуудын Аюук хааны ордонд хүрч бараалхсан билээ.

Энэхүү Ману тохой гэдэг газар нь их төлөв Астрахан мужаас хойших Волгоград болон Райгород хоорондох Ижил мөрний баруун хөвөө дагуу их тал дээр байсан юм [Ма Дажэн 1991: 105]. Энэ орчим бол мөн ч Жангар хааны ордны байршлын орон байр мөн гэдгийг дээрх хэдэн хэсэгт тодорхойлсон билээ. Чин улсын хааны захидал бичигт хүртэл Торгууд хаант улсын нутаг дэвсгэрийг *‘Вэ зан’* буюу *‘Үйзэн’*-ий орон гэж хэлж байснаас үзвэл Торгууд хаант улсын нутаг дэвсгэрийг үнэхээр *‘Үйзэнгийн орон’* гэж эртдээ хэлж байсан бололтой.

Ингэхлээр «Жангар»-ын тууль дахь *‘Ар бумбын орон’* хийгээд *‘Үйзэнгийн орон’* гэдэг нь адилхан утгатай байж, цөм Торгууд хаант улсын нутаг дэвсгэрийг заасан утгатай аж. Харин *‘Үйзэн алдар хаан’* гэвэл *‘Үйзэнгийн орны хаан’* гэсэн утгатай үг болно.

‘Үйзэн’ гэдэг үг бол гарлын хувьд төвд үг болох бөгөөд Лхасаар төв болгосон өмнөд Төвд орныг заасан *«Үй» (dbus)*, Ригазигээр төв болгосон хойт Төвдийг заасан *«зан» (gtsang)* гэсэн хоёр үгээс нийлэн бүтсэн *‘Үйзэн’* гэдэг үг болох юм. Энэ үг нь Мин улсын сүүлч, Чин улсын эхний үеэр Төвд орныг заасан төлөөний нэр байсан ба XVII зуунаас хойш монголын түүхэн бичигт олонтоо тохиолдох нэр цол болжээ.

6. Хар тэнгис

Эрклүүһин Мөңгн Цаһан / Уул деер һарч гинэ. / Ут занон арман түшэд, / Довтлх шонхрин нүдэр, / Долан орни амтиг, / Энд уга анхрәж гинэ. / Цаад бийдән хэләхнэ, / Найн тавн сара / Өргн киитн хар теңс / Өрү-сөрү хойр урсхулта, / Урсхулдн үкрин дүнгә хар чолун / Бий бийән гүвдлән, / Улан һал падрад, / Уулын дүнгә цаһан долган / Унду-сунду цокад бәәв [Жаңһр 1990: 234–235] — хэмээн Хар тэнгисийн тухай дүрсэлсэн дүрслэл нь догшин урсгал, ширүүн давалгаатай Хар тэнгисийн бодит байдалтай нийцэж буй.

Бас: *Киитн хар теңгсин көвәд бәәсн / Гүзән Гүмбиниг би дәәлнәв! — гижә йовна* [Жаңһр 1990: 91] — гэдгээс үзэхэд «Жангар»-ын шилдэг арван гурван баатрын нэгэнд тооцогдох Гүзән Гүмбийн нутаг нь энэ Хар тэнгисийн хөвөөнд байдаг аж.

7. Хойт мөсөн далай

Зургаадагч жилийн адаг сүүлээр, / Хойт мөсөн далай бүслүүртэй / Эргүү хоймостой Догиин Шар мангас [Жангар 1986: 29].

Түүнээс ондоо бас нэг хаан байж гэнэ, / Тэрхааныг хэлдэг болохула, / Эвхэрсэн мөсөн цагаан далай бүслүүртэй, / Эрс цагаан уул түшлэгтэй [Жангар 1986: 53] — гэх мэтээр дүрслэгддэг ба түүний зүг чиг нь *«хойт зүгт байдаг»* [Жангар 1986: 62] аж.

Үүнээс энэхүү *‘Хойт мөсөн далай’* гэдэг нь одоогийн Умард мөсөн далай мөн гэдгийг нэр болон зүг чигийн талаас мэдэж болно.

8. Хүүхэн цагаан тэнгис

«Жангар»-т: *Хүүхэн цагаан тэнгисийн гурван буланг / Хий цовлон гарайдаад, гадацад нь гарав* [Жангар 1986: 225] — хэмээн өгүүлдэг.

Энэ *‘Цагаан тэнгис’* гэдэг нь одоогийн Оросын Мурманск болон Архангельск хоёрын хооронд байдаг, энэ нь «Жангар» дахь *«Ар бумбын орон»*-ы эгц зүүн зүгт (уламжлалт наран зүгээр) байдаг *‘Цагаан тэнгис’* болох болов уу хэмээн бодож байна. Т. Жамцаа гуайгаас тус тэнгисийг одоогийн Турк улсын баруун захад байх Эгийн тэнгис мөн байх [Жамцаа 1997: 156] хэмээн үзсэн болно.

9. Авхуй балгад далай болон Богдын уул

«Жангар»-т: — *Алтан Цээж бава минь, / Зүүн өмнө зүгт / Авхуй балгад далайн хөвөөнд, / Шихэр тавцан гэдэг уулын / Баруунсууд нутагласан / ... / Буурал һалзан морьтой, / Бумбын Хар Санал гэдэг хаан байна* [Жангар 1986: 177–178] — гэж тоочсон байдаг.

Энд хэлж байгаа *‘Авхуй балгад далай’* гэдэг нь чухам хаана байх болов хэмээн *«Ар бумбын орон»*-ы зүүн өмнөд зүгт орших газар нутаг дотроос эрэн хайсанд Чив хэмээн одоогийн Хасагстаны баруун хойт хэсэг, Урал голын дунд урсгалын сав газарт байх Уральск мужийн хил дотор байх зургаан ихцэр нуур тэнгисийн нэгийг “Балгад” хэмээн тов тодорхой бичиж байхыг [Справочник 1994: 93] эрж оллоо.

Бас жишээлбэл: *Хоёрдогч суурьт суудаг нь хэн бэ? гэвэл, / ... / Богдын өндөр уулаа ясаар нь тайгаад, / Булинггар улаан далайгаа цусаар нь тахиад, / Бум сая нутаг нуруугаа / Эр биеэрээ харсан байдаг, / Булинггарын хөвүүн Догиин Хар Санал болно* [ЖЭМ-8 1988: 29] — гэж өгүүлдэг.

Энд хэлж байгаа *‘Богдын уул’* гэдэг нь дээр өгүүлсэн *‘Балгад далай’*-н орчим буюу одоогийн Хасагстаны хил доторх Турхай голын баруунтаа Урал голын зүүнтээ байдаг их Богд уулыг зааж байгаа нь илэрхий.

Харин *‘Буллинггар улаан далай’* гэдэг нь энэ орчимд байдаг 140 гаруй нуур тэнгисийн [Справочник 1994: 93] доторх аль нэг нь бололтой. Энэ Булингарын хөвүүн Догшин Хар Санал сүүлээр нь *«бум түмэн албатаа ноён үгүй орхиод, бурхан сайхан ээжээ үр үгүй хаяад»* Жангарт орж өгсөн байдаг.

Энэ бүхнийг дүгнэж хэлбэл, *«Жангар»* дахь *‘Авхуй балгад далай’* хийгээд *‘Богдын уул’* (үнэхээр Хасагстаны баруун хойт хэсэг дэх хамгийн өндөр уул болно) гэдэг нь одоогийн Хасагстаны баруун хойт хэсэг, Арал тэнгисийн баруун хойт бие, Каспийн тэнгисийн зүүн хойт талд байдаг *‘Балгад далай’* хийгээд *‘Их Богд баявуул’* гэдгийг их төлөв магадлаж болно.

10. Шихирлуу

Энэ Богдын уул хийгээд Балгад далайн орчимд бас нэг Шихирлуу гэдэг томоохон гол байдаг тухай дээрх номд тодорхой тэмдэглэжээ. Энэ нь *«Жангар»*-т олон дахин гараад байдаг *‘Шихирлуу’*-г зааж байгаа болов уу? *«Жангар»*-т:

Шихирлуугийн хөвөөнд байдаг / Шигширгийн өргөөнд хурч, / Араг Улаан Хонгорт, / Энэ бичиги өгө. / Ойроор тавиад бодохула, / Үдийн газар биш үү, / Холоор тавиад бодохула / Хоногийн газар биш үү [Жангар 1986: 221].

Хүчтэй баатар Хонгор / ... / Ингэтэл тэгтэл хүлээлгээд, / Эрчис бумбаараа ороод / Бумба далайн хөвөөнд, / Богд ноён Жангарынхаа / Хас мөнгөн үүдэнд ирж буугаад [Жангар 1986: 221–230] — гэсэн нарийн тоочилт байдаг, үүнээс Хонгорын нутаг бол *‘Шихирлуу’* гэдэг голын хөвөөнд байдаг ба энэ нь Жангарын хаан ордноос дэмий холгүй газар байдаг гэснийг мэдэж болно.

Энд зүг чигийн талаар тодорхой заалт хийсэнгүй боловч *‘Эрчис бумбаараа ороод’* гэснээс үзвэл *‘Шихирлуу’* нь Жангарын хаан ордны зүүнтээ талаар байх бололтой. Олны мэдэгчээр 1771 онд торгуудууд Ижилээс эх улсдаа буцаж ирэхдээ энэхүү *‘Шихирлуу’*-г дамжин өнгөрсөн тухай чухал баримт буй.

Энэ нь даруй торгуудууд Ижилээс буцаж ирэх үе, нүүдэл дайсны цэргүүдтэй тулалдаж баатарлагаар бие үрэгдсэн баатар эр Анай баатарлагийн тухай дахь дурсамж дуу болно. Тус дууны тухай хэд хэдэн хувилбар байдаг боловч газар усны нэрсийн талаар харин бүр нэгдэлтэй байдаг.

Жишээлбэл: *Хармаг луугийн хөвөөнд / Хар саарал нь хазаар эмээлтэйгээ*

хантраатай, / Хайрладаг нутгийнхаа төлөөд / Аанай Бардаанаг хайртай шиг амийгаа өргөв, / Шихирлуугийн хөвөөнд шихирдсэн цахараараа цахардчихлаа, / Шихийгээд ирсэн дайсныг Аанай Бардаанаг, / Шивэлзсэн саарлаараа сөргөв [Зоригтой 1984: 16] гэж дуулдаг.

Үүнээс *«Жангар»* дахь *‘Шихирлуу’* болон тус түүхэн дуу дахь *‘Шихирлуу’* гэдэг нь бүр нэг газрыг зааж байгаа үнэн бодот газрын нэр мөн гэдгийг мэдэж болно. Т. Жамцаа гуай *‘Шихирлуу’*-г одоогийн Монгол улсын Ховд Алтайн орчим буй [Жамцаа 1997: 163] хэмээн үзсэн байна.

11. Шихир дөрвөн далай буюу Баримадын гурван далай

«Жангар»-ын адил бус хувилбарт *‘Шихир дөрвөн далай’*, *‘Баримад гурван далай’* гэж үргэлж гардаг. Жишээлбэл:

Шихир дөрвөн далай гэдэг нь / Баруун зүүн хоёроос нь бүслээд, / Барчид зэтгэр хоёрыг бууж тосоод, / Хорон шоогоор буцалдаг гэнэ [Жангар 1986: 11] — гэх мэтээр дүрсэлдэг.

Үүнээс *‘Ар бумбын орон’* буюу нэн тодруулж хэлбэл Алдар Жангарын алаг шар бамбалайн эргэн тойронд нь гурав буюу дөрвөн далай байдаг юм байна. Энэ нь Торгууд хаант улсын нутаг дэвсгэрийн зүүн баруун биед орших Арал тэнгис, Каспийн тэнгис, Хар тэнгис, Цагаан тэнгис буюу эсвэл Дон мөрний цутгалан болох Азовын тэнгис зэргийг зааж байгаа нь тодорхой. Алтай, Тарвагатайн орчим дахь зүүнгарын нутаг усны зүүн баруун талд нь иймэрхүү том далай тэнгисүүд байдаггүй, үүнийг анхааран үзүүштэй.

12. Өл манхан цагаан уул

Алдар Жангарын алаг шар бамбалай нь энэхүү Өл Манхан Цагаан уулын өлгүүнд байдаг. Энэ тухай: *Өл Манхан Цагаан уул нь / Газар тэнгэр хоёрын хүйсэн болоод, / Өглөө гарах нарны хөл доор / Манхайгаад байдаг гэнэ / ... / Эзэн ноён Жангартая, / Энэ наран доор үгүй байшин бариулъя / ... / Наран гарахын ар бие тал, / Гурваних иилийн омруун тал, / Артай арван хоёр далайн цутгаланд, / Бумба далай гэдэг далайн хөвөөнд, / Өл Манхан Цагаан уулын баруун эрүү доор, / Талбайн цагаан ташууд / Таван зуун галбир зандан улиасыг / Дагуулъя гэж хүүрнэлдсэн болно [Жангар 1958: 20]* — гэж өгүүлдэг буюу.

Өл Манхан цагаан уулын өлгүүнд, / Өргөн Шарт далайн цутгаланд, / Алтан арлуудын

аараг дунд, / Араат арван хоёр бүслүүртэй / Талбиу цагаан таиуугийн нүүрт, / Таван мянган галбир занданы / Сүүдэр дагуулья гэж зөвшилдөөд [ЖЭМ-8 1988: 39–40] — гэх мэтээр нарийн дүрслэн тушаасан байдаг.

Энэ уулын зүг чигийн талаар ‘Бумбын орон’ буюу Жангарын хаан ордны аль зүгт нь байх болов хэмээн «Жангар»-ын туулийг нарийн шүүж үзсэнээ «Алтан Цээж Жангар хоёрын байр барилдсан бүлэг»-т энэ асуудлыг тодорхой тушаасан байна. Даруй Алдар ноён Жангарыг эрхэм таван настайд нь Түвшин ширгийн хөвгүүн, Бөх Мөнгөн Шигширгэ олзод авдаг ба сүүлээр нь түүнийг бусдын гараар хороож алуулахын төлөө, Алтан цээжийн адууг хөөлгөхөөр явуулна. Тэгээд Алдар Жангар:

Дэжн нурвн сара нэзрт гүүлсэн цагт, / Эл Манхн Цаган уулын ора харһад ирв. / Күрс-күрсэр күрч ирэд, / Шүһл мөңгн цулвран суңһж бэрэд, / Дэрсин хар елдңгэн чирэд, / Киитн хар нүдэрн дөрвн талан хэлэв. / Байн Күңкэн Алтн Цеежсин / Барвад алтн бээшн бас чиг харгдв [Жаңһр 1990: 17] — гэж тодорхой тушаасан байдаг.

Дээрх хоёр жишээнээс доорх мэт хэдэн сүвэгч илэрч байна. Нэгд, энэхүү ‘Өл манхан цагаан уул’ гэдэг нь тэнгэр газрын хүйс болсон маш өндөр уул юм. Хоёрт, энэ уул нь Алдар Жангарын ‘Ар Бумбын орон’-ы баруун буюу баруун хойт зүг болох «наран суух үд хоёрын хооронд» байдаг байна. Гуравт, Жангарын хаан ордон нь энэхүү өндөр уулын өлгүүн омруун талд, Бумба далайн хөвөөнд байдаг байна. Энэхүү чухал хэдэн сүвэгчид тулгуурлан Ижил, Дон, Урал зэрэг гурван мөрний өргөн уудам сав газруудын хоорондох уул нуруудыг ажиглан үзэхээр ихэнх газар нь бүр үзүүр хязгааргүй тэгш тал байж, харин ‘тэнгэр газрын хүйс’ болмоор өндөр уул нэг ч харагдсангүй.

Гагцхүү ‘Ар бумбын орон’-ы баруун зүг буюу баруун хойт зүгт, бүр тодруулж хэлбэл, Хар тэнгис болон Каспийн тэнгисийн хооронд залгалдсан их Кавказын уулын дунд хэсэгт нь үнэхээр нэгэн «Өл Буурал уул» (Эльбрус уул) гэдэг хамгийн өндөр оргил байхыг олж мэдлээ [Селеева 2013: 270]. Тус уулыг хятадаар «*Erbülüshi*» гэж тодорхой тэмдэглэж байдаг бөгөөд энэ уул нь далайн түвшнээс 5633 метр өндөр уул аж. Ингээд нэр усны талаар ч, өндрийн хэмжээгээрээ ч, зүг чиглэлээрээ ч, энэхүү уул нь “Жангар” дахь ‘Өл Манхан Цагаан уул’-ын байдалтай яахын аргагүй тохирч байна.

13. Мин уул

«Жангар»-т Орчлонгийн сайхан Минъян гэдэг олон талын авъяас, эрдэм, арга чадалтай эрхэм сайн сөнчийн дүр гарна. Угтаа тэр бас

Мин гэдэг уулын түшлэгтэй, / Мин гэдэг голын услууртай, / Мянган түмэн өрх албаттай, / Эрх Туг хааны хөвгүүн, / Орчлонгийн сайхан Минъян гэдэг [ЖЭМ 1988: 205] хаан байжээ.

Түүний нутаг усных нь байдал бол

Мин гэдэг уул түшлэг нь, / Мангнуг торгоор бүрхсэн адил / / Мин гэдэг гол тэнгисэд нь / Мунрашаан бүрэдүсэн байна [ЖЭМ 1988: 203];

Дээрээн даранга дажрал үгүй, / Дэргэдээндайн дажсин үгүй, / Орчлондундаа хувьдаа жаргалтай, / Өчүүхэнхааны нутаг гэгсэр / ... / Өчүүхэн байтал яагаад үүнд / Ороннутгаа харсагсан буй? — гэж / Хаан ноён Жангар бодоод, / Омог сэтгэлээр гайхахлаа нь / Өчүүхэн орон болсон болоод байдагаж [ЖЭМ-8 1988: 203];

Гэвч энэхүү «найтаг тивийн өчүүхэн орон билэй, найман үедээн бүрэн бүтэн билэй» [ЖЭМ 1988: 220] байж байгаад, Орчлонгийн сайхан Минъян Жангар хаан лугаа байр барилдах үедээ түүний аугаа их хаан болох тухай хүчин чадал ба хишиг буяныг шинжлэн мэдээд:

Мин гэгч уулаан / Эзэнгүй хаяад, / Мянган түмэн албатаан / Ноёнгүй орхиод, / Цуудай цагаан хатнаан / Ганц биеэр нь хаяад, / Цусан улаан хүүхнээн / Аавгүй орхиод, / Алтан Шаргаараан ирээд [Жангар 1986: 340] алдар ноён Жангарыг дагаж, эрхэм сайн сөнч нь болдог.

Дээрх жишээ бидэнд ийм хоёр чухал сүвэгчийг хангаж буй. Нэгд, Минъяний нутаг бол ‘Мин’ гэдэг уул ба “Мин” гэдэг голтой байдаг, өөрөөр хэлбэл Минъяний нутаг бол ‘Мин’ гэдэг нэртэй байсан байна. Хоёрт, Минъяний энэхүү ‘Мин’ нэртэй улс нь ‘өчүүхэн орон’ болно. Одоо бид дээрх хоёр сүвэгчид нэг нэгээр задлал хийж үзье.

1. ‘Мин’ гэдэг уул ба ‘Мин’ гэдэг улс байсан эсэх тухай. Ази тивд ‘Мин’ гэдэг нэртэй уул ус байх эсэх тухай тодорхой баримт байхгүй, гэвч дундад улсын түүхэнд ‘Мин’ улс гэдэг төр гүрэн тогтож байсан, үүнээс шалтгаалан зарим судлагчид орчлонгийн сайхан Минъянийг ‘Мин улс’-тай ямар нэгэн харьцаатай болов уу гэсэн санаа гаргаж байсан. Бидний бодлоор, «Жангар»-т гардаг энэхүү ‘Мин уул’ гэдэг нь одоогийн Азарбайджаны хойт бие, Оросын европын хэсгийн өмнө тал, Хар тэнгисийн

зүүн хөвөө дагуу байдаг «Гүрж улс»-ын зүүн хойт зүгт байдаг уулыг хэлж буй.

Тус уул далайн түвшнээс 4008 метр өндөр байдаг ба нэр нь «Мингрэлиа» гэдэг аж. Тус уулыг «Орос улсын түүхэн газар зургийн тайлбар» гэх ном дээр хятдаар «Minggèlièliya» [Карта России 1995: 76] хэмээн тодорхой тэмдэглэж байна. Харин одоогийн газрын зургууд дээр хятдаар /ханз/ гэж дөхөмжлөн тэмдэглэж буй. Хэрвээ орос бичлэгийн уг тэмдэглэлийг олж чадсан бол энэ асуудал улам тодорхой болох байсан. Тэгвэл түүхээс энэ уулын орчимд «Мин» гэдэг улс гүрэн оршиж байсан уу? — гэвэл үнэхээр «Мин» гэдэг улс байсан байна.

Тус улс нь эртний «Гүрж улс» дотроос биеэ дааж тусгаарлан гарсан жижигхэн улс байсан ба түүнийг хятдаар «Minggè lièliya gōngguó» хэмээн тэмдэглэж буй. Тус улсыг Хаант Оросоос 1804 онд эрхшээлдээ оруулж 1867 онд жинхнээр нэгтгээд [Карта России 1995: 76] авчээ. Дээрх хоёр баримтаас «Жангар» дахь «Мин» гэдэг уул болон «Мин» гэдэг улс нь даруй түүхэн дэх үнэн бодит «Мин» уул болон «Minggè lièliya gōngguó» улсыг зааж байх нь их төлөв тодорхой байна.

2. Энэхүү «Minggèlièliya» улс нь угийн өчүүхэн бага «Гүрж улс» дотроос салбарлан гарсан нэн бага улс болохоор «Жангар»-т түүнийг «Өчүүхэн орон» хэмээн онцлон тодруулж хэлэх нь түүхэн үнэнтэй нэн ойртож байна.

Олны мэдэж байгаагаар, «Жангар»-ын туульд «Орчлонгийн сайхан Минъян Түрэг хааны шар цоохор агтыг хөөсөн бүлэг» болон «Орчлонгийн сайхан Минъян хүчтэй Хэрэмэн хааныг амьдаар барьж ирсэн бүлэг» гэдэг тусгай хоёр бүлэг байдаг. Энэ хоёр бүлэгт Орчлонгийн сайхан

Минъян Жангарын зарлигаар явж, Түрэг хааны адууг хөөж ирдэг ба хүчтэй Хэрэмэн хааныг амьдаар нь барьж ирдэг үйл явдал өгүүлэгдэнэ. Олны мэдэгчээр дээр дурдсан «Мингрэл улс»-ын нутаг усны байршил нь Чив хэмээн Түрэг ба Крымийн хооронд хил залгалдан оршин тогтнож байсан «Өчүүхэн улс» болно. «Жангар» дахь «Мин улс»-ын байршил нь ч энэхүү түүхэн бодит байдалтай яг тохирч байна. Үүнээс «Жангар» дахь Орчлонгийн сайхан Минъянтэй холбогдсон өгүүлэмж бол нэлээд бат бэх түүхэн үндэс сурвалжтай учир явдал бололтой гэдгийг төсөвлөж болох юм.

Бас цаашилбал, Орчлонгийн сайхан Минъянийг өөр зүгт зарахгүй яг өөрийнх нь нутаг устай зэргэлдээ байсан Түрэг хаан болон Хэрэмэн хааны нутагт элчлэн зарсан явдал нь ч түүнийг тэр орчмын бүх талын нарийн байдлыг илүү тодорхой сайн мэднэ гэж үзэж байсантай шууд холбогдох бус уу? Сонирхолтой нь, алдар Жангар хаанаас Орчлонгийн сайхан Минъянийг зарлигдаж Түрэг хаан ба Хэрэмэн хааны нутаг зүг зарах үед, орчлонгийн сайхан Минъян:

Хариин ик дээсенде / Ганцъ бийе миний юуңгад сөрдегтен энүве? / Өнчин гижси өөсентен энүве? / Өнер болад, эне улъс суусън энүве? / Хәре һазъртъ хатрад йовхъла / Халун хәәсен хот өгдөг / Эгчи, дүүһин оңһа үга л! / Ардъ санжъ кэлдег минь / Ах, дүүһин оңһа үга л! [Жаңһр 1978: 419–420] — гэж хэлдэг, үүнээс Орчлонгийн сайхан Минъян бол Жангар, Хонгор нартай ямар ч төрөл садны харилцаагүй харь овгийн хүн буюу харь үндэстний хүн болох нь их төлөв мэдэгдэж байна. Энэ нь ч Минъянийг түүхэн дэх «Мингрэл улс»-ын хаад ноёдын туульжсан дүр мөн гэдгийг батлах хамгийн сайн дам баримт мөн.

Ном зүй / Литература

Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ 1992 — Бадай Х., Алтан-Оргил, Эрдэнэ. Ойрад түүхийн дурсгалууд. Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1992. 496 н.
Борисенко 2004 — Борисенко И. В. Географические реалии эпоса «Джангар» по картографическим источникам // «Джангар» и проблемы эпического творчества. Мат-лы Междунар. науч. конф. (г. Элиста, 22–24 августа 1990 г.). Элиста: АПП «Джангар», 2004. С. 390–392.

Жамцаа 1997 — Жамцаа Т. Тууль «Жангар»-ын учир. Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1997. 516 н.

Жангар 1958 — Арван гурван бүлэгт «Жангар». Хух-Хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1958. 341 н.

Жангар 1986 — Жангар. 1 боть. Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1986. 861 н.

ЖЭМ-8 — Жангарын эх материал. 8. Урумчи: Дундад улсын ардын аман зохиол урлагийн хэвлэлийн хороо, 1988. 501 н.

- Жаңһр 1978 — Жаңһр. Хальмг баатрлг дуулвр (25 бөлгин текст). I боти. М.: ГРВЛ, Наука, 1978. 442 с.
- Жаңһр 1990 — Жаңһр. Хальмг баатрлг эпос. Хурвдгч харцнь. Элиста: Хальмг дегтр харһач, 1990. 286 с.
- Зоригтой 1984 — Зоригтой Н. Ховогсайрын монгол урт дуу. Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1984. 224 н.
- Карта России 1995 — Обоснование исторической карты России. Пекин: Коммерческое изд-во, 1995. 380 с.
- Кичиков 1976 — Кичиков А. Ш. Исследование героического эпоса «Джангар» (Вопросы исторической поэтики). Элиста: Калмыцкое кн. изд-во, 1976. 155 с.
- Кичгэ 1974 — Кичгэ Т. Баатрлг дуулвр «Жаңһр» (Баатрлг дуулврин харлһин, баг бөлгүдин, теднэ холлгч баатрмудын, утх багтаврин шинжлһн). Элст: Хальмг дегтр харһач, 1974. 159 х.
- Козин 1940 — Козин С. А. «Джангариада». Героическая поэма калмыков (введение в изучение памятника и перевод торгутской его версии). М.; Л., 1940. 252 с.
- Ма Дажэн 1991 — Ма Дажэн, Ма Рушэн. Этносы, ушедшие в другие страны. Пекин: Изд-во АОН КНР, 1991. 183 с.
- Селеева 2013 — Селеева Ц. Б. Указатель тем калмыцкой и синьцзян-ойратской версий эпоса «Джангар». Элиста: КИГИ РАН, 2013. 276 с.
- Справочник 1994 — Справочник пяти стран Центральной Азии. Урумчи: Изд-во науки и техники Синьцзяна, 1994. 220 с.
- Vol. 1. Moscow: Nauka, GRVL, 1978. 442 p. (In Kalm.)
- Dzhangar* [The *Jangar*]. Vol. 1. Urumqi: Xinjiang People's Publ. House, 1986. 861 p. (In Mong.)
- Dzhangar. Khal'mg baatrlg epos* [The *Jangar*: a Kalmyk heroic epic]. 3rd ed. Elista: Kalmyk Book Publ., 1990. 286 p. (In Kalm.)
- Karta Rossii. Obosnovanie istoricheskoi karty Rossii* [A substantiated historical map of Russia]. Beijing: Commercial Publ. House, 1995. 380 p. (In Chin.)
- Kichikov A. Sh. *Issledovanie geroicheskogo eposa «Dzhangar» (Voprosy istoricheskoy poetiki)* [Investigating the heroic epic of *Jangar*: questions of historical poetics]. Elista: Kalmyk Book Publ., 1976. 224 p. (In Rus.)
- Kichgä T. *Baatrlg duulvr «Dzhangar» (Baatrlg duulvrin yarlyin, bag bölgüdin, tedne yollgch baatrmudyn, utkh bagtavrin shinzllyn)* [The heroic epic of *Jangar*: an insight into origins of the epic, repertoire cycle, main characters, artistic content]. Elista: Kalmyk Book Publ., 1974. 159 p. (In Kalm.)
- Kozin S. A. *«Dzhangariada». Geroicheskaya poema kalmykov (vvedenie v izuchenie pamyatnika I perevod torgutsКОЙ ego versii)* [The *Jangariad*: a heroic poem of the Kalmyks (an introduction to epic studies supplemented with a translation of the Torghut version)]. Moscow; Leningrad, 1940. 252 p. (In Rus.)
- Ma Dazhehn, Ma Rushehn. *Etnosy, ushedshie v drugie strany* [Ethnic groups that have left for other countries.] Beijing: Publ. House of China, 1991. 183 p. (In Chin.)
- Seleeva Ts. B. *Ukazatel' tem kalmytskoy i sin'tsyan-oiratskoy versiy eposa «Dzhangar»* [The Kalmyk and Xinjiang Oirat versions of the *Jangar* epic: an index of themes]. Elista: Kalm. Hum. Res. Inst. of RAS, 2013. 276 p. (In Rus.)
- Spravochnik pyati stran Tsentral'noi Azii* [Five Central Asian countries: a reference book]. Urumqi: Xinjiang Science and Technology Publ. House, 1994. 220 p. (In Chin.)
- Zhamtsaa T. *Tuul' «Zhangar»-in uchir* [The *Jangar* Epic]. Urumqi: Xinjiang People's Publ. House, 1997. 516 p. (In Mong.)
- Zhangarin ex material. 8* [Original texts of the *Jangar. 8*]. Urumqi: Publ. House for Oral Arts of Peoples of China, 1988. 501p. (In Mong.)
- Zorigtoi N. *Khovogsayryn mongol urt duu* [Lingering songs of Qobuqsar Mongols]. Urumqi: Xinjiang People's Publ. House, 1984. 224 p. (In Mong.)

References

- Arvan gurban bulegt «Zhangar» [Thirteen chapters of the *Jangar*]. Hohhot: Inner Mongolia People's Publ. House, 1958. 341 p. (In Mong.)
- Badai X., Altan-Orgil, Erdene. *Oirad tuukhiyn dursgaluid* [Works on Oirat history]. Urumqi: Xinjiang People's Publ. House, 1992. 496 p. (In Mong.)
- Borisenko I. V. Geographical realia of the *Jangar* epic according to cartographic sources. «*Dzhangar*» i problemy` epicheskogo tvorchestva. Conf. proc. (Elista, 22–24 August 1990). Elista: Dzhangar, 2004. Pp. 390–392. (In Rus.)
- Dzhangar. Khal'mg baatrlg duulvr* [The *Jangar*: a Kalmyk heroic epic]. Texts of 25 chapters.

